МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 19 өдөр Дугаар 185 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/132 дугаар тушаалаар батлагдсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн салбарт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд "Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж байхыг харьяа байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөл /Ж.Гантөмөр/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2017 оны 09 дүгээр сарын 19-ны
өдрийн 185 дугаар тушаалын
хавсралт

## Зам, тээврийн салбарт “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцах газар |
|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх** | | | | |
| 1.1 | Хөдөлмөрийн мөлжлөг ялгаварлан гадуурхлын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган, хэрэгжилтийг ханган ажиллах | 2017-2021 | Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан байна. | ТЗУГ, ХШҮДАГ, харьяа байгууллагууд |
| 1.2 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар харьяа байгууллагуудад сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах | Жил бүр | Сургалтанд хамрагдсан байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 1.3 | Эрэгтэй, эмэгтэй хүн, нийгмийн бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байрыг бий болгох сайн туршлагуудыг судлан нэвтрүүлэх | 2018-2021 | Сайн туршлагыг нэвтрүүлсэн байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 1.4 | Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар эмнэлэгийн нарийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах | Жил бүр | Эмчийн үзлэгт хамрагдсан байна. | ТЗУГ, байгууллагууд |
| **Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх** | | | | |
| 2.1 | Жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах тусгай программыг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх | 2018 | Программ хангамж хэрэглэхэд бэлэн болсон байна | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 2.2 | Жендэрийн статистикийг бүх түвшинд бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлалыг албан хэрэгт ашиглах | 2018-2021 | Аргачлал батлагдаж ашиглахад бэлэн болсон байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 2.3 | Зам, тээврийн салбарын бодлого төлөвлөлт жендэрийн мэдрэмжтэй хийгдэж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | 2018-2020 | Жилд 1-ээс доошгүй удаа үнэлгээ хийсэн байх | ХШҮДАГ |
| 2.4 | Төсөвлөгчийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн он-лайн сургалтанд хамрагдах | 2017-2021 | Сургалтанд хамрагдсан байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| **Зорилт 3. Бүх нийтийн жендэрийн боловсролыг дэмжсэн, эмэгтэй, эрэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн гэгээрэл сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлнэ.** | | | | |
| 3.1 | Гэр бүлийн гишүүд бие биенээ хүндлэх, дэвшилтэт уламжлалд суурилсан ёс суртахуун, хүнлэг чанарыг эрхэмлэх, зөв, эрүүл амьдралын зан үйлд суралцах, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулах | 2017-2021 | Сургалтын төлөвлөгөө батлуулсан байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2 | Гэр бүлийн үнэн цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах болон сайн үлгэр болох гэр бүлийн жишээг сурталчлах | 2017-2021 | Сурталчилгаа хийгдсэн байна | ТЗУГ, харъяа байгууллагууд |
| **Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхийг бэхжүүлэх** | | | | |
| 4.1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэнд үр нөлөөний үнэлгээ хийх | 2018-2020 | Үнэлгээ хийгдсэн байна | ХШҮДАГ |
| 4.2 | Удирдах ажилтанд зориулсан жендэрийн онлайн сургалтанд хамрагдах | 2017-2018 | Сургалтанд хамрагдсан байна | ТЗУГ |
| 4.3 | Салбар зөвлөлийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх | 2017-2021 | Зөвлөмж хүргүүлсэн байна. | Салбарын харьяа байгууллагууд |
| **Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | |
| 5.1 | Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх асуудлаар салбарын хэмжээнд сургалт зохион байгуулах | 2017-2019 | Сургалт зохион байгуулагдсан байна. | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 5.2 | Гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт явуулах, гэр бүлийн болон сэтгэл зүйн сургалт зохион байгуулах | 2018-2020 | Сургалт зохион байгуулагдсан байна | ТЗУГ, харьяа байгууллагууд |
| 5.3 | Ажлын байран дахь аливаа дарамтаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах | 2018-2021 | Үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна. | ТЗУГ, харъяа байгууллагууд |
| **Зорилт 6. Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх** | | | | |
| 6.1 | Төрийн жинхэнэ албаны албан тушаалд санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэхэд Жендэрийн хуульд заасан квотыг анхаарах | 2018-2019 | Тодорхой ажиллагаа хийгдсэн байна. | ТЗУГ, харъяа байгууллагууд |